



## НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

2014.03.26. № 519  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ  
МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Б.БАДРАЛ  
ТАНАА

### АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын нийтийн аж ахуй тохижилт үйлчилгээний зардлын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон холбогдох илчлэл тодруулгад Нийслэлийн Аудитын газрын санхүүгийн аудитын I албаны I баг аудит хийлээ.

### Үүрэг хариуцлагын талаархи мэдэгдэл

Захирагчийн ажлын албаны удирдлага Улаанбаатар хотын нийтийн аж ахуй тохижилт үйлчилгээний зардлын санхүүгийн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэгтэй.

Санхүүгийн нэгдсэн тайлан УСНББОУС, Сангийн сайдаас баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар, журмын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн Аудитын газрын үүрэг юм.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын Үндэсний Аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлсийг сорилын үндсэн дээр шалгадаг. Захирагчийн ажлын албаны удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, баримталсан бодлого, хийсэн чухал тооцоолол, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үндэслэл болсон.

1110400519

Монгол Улсын төсвийн байгууллагуудад мөрдүүлж байгаа Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын заавар, журам нь УСНББОУС-ын заримтай нийцэхгүй байна. Тухайлбал: Төсвийн байгууллагууд санхүүгийн тайлангаа аккруэл сууриар бус, аккруэл-мөнгө хольсон сууриар тайлагнаж байхаар журамласан нь авлага, өглөг, хөрөнгө, тайлант үеийн орлого, зардал, үр дүнгийн үзүүлэлтүүд олон улсын стандартаас зөрүүтэй илэрхийлэгдэх магадлалтай.

Сангийн яамнаас нэгэнт бүх төсөвт байгууллагуудад дээрхи заавар журмыг мөрдүүлсэн учраас санхүүгийн тайланг түүнтэй нийцүүлэн аудит хийв.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Захирагчийн ажлын албаны Улаанбаатар хотын нийтийн аж ахуй тохижилт үйлчилгээний зардлын 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг зөрчилгүй толилуулсан байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц. ОЧИРБАТ